



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ**

2013 оны 11 сарын 15 өдөр

Дугаар A-213

Улаанбаатар хот


Журам батлах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 4.9.2 дахь заалт, Ректорын зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн профессор багш нарыг аттестатчилах, профессорын баг тэнхимийн рейтинг тогтоох журмыг нэгдүгээр хавсралтаар, аттестатчилалын үндсэн шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Ректорын 2010 оны А-169 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

РЕКТОР



Б.ОЧИРБАТ



Ректорын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны
өдрийн 11/13 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

ШУТИС-ийн ПРОФЕССОР БАГШ НАРЫГ АТТЕСТАТЧИЛАХ, ПРОФЕССОРЫН БАГ, ТЭНХИМИЙН РЕЙТИНГ ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмыг ШУТИС-ийн профессор багш нарын сургалт, эрдэм шинжилгээ, сургууль, олон нийтийн үйлчилгээний ажлыг нэгтгэн үнэлж, аттестатчилах, улмаар профессорын баг, тэнхимийн үйл ажиллагааг дүгнэн, тэдгээрийн рейтинг тогтооход баримтална.

- 1.1. Профессор багш нарыг аттестатчилах, профессорын баг, тэнхимийн рейтинг тогтоох ажлыг 3 жил тутамд явуулах бөгөөд энэ нь багш нарыг хөгжүүлэх, бүтээлч үйл ажиллагааг нь дэмжих, идэвхжүүлэх, багш нарын албан тушаалын зэрэглэл, шатлал өөрчлөх, хөдөлмөрийн гэрээг сунгах, эс сунгах, тухайн профессорын баг, тэнхимийн талаар авах арга хэмжээг төлөвлөх, үйл ажиллагааг өргөжүүлэх, дэмжих, санхүү, хөрөнгийн болон, ажиллах хүчний нөөцөөр бэхжүүлэх, нэгтгэх, татан буулгах, тэргүүлэх профессор, тэнхимийн эрхлэгч нарын гэрээг сунгах, цуцлах, үр дүнгээр цалинжуулах, шагнал урамшилд дэвшүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл болно.
- 1.2. Журмыг ШУТИС-ийн ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Ректорын тушаалаар батлан мөрдөх ба хэрэгжүүлэх явцад өөрчлөлт оруулах саналыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж байна.


Хоёр. Профессор багш нарын ажлын нэгдсэн үнэлгээний агуулга, үнэлэх арга, ажиллагаа

- 2.1. Өмнөх аттестатчилалаас хойш профессор багшийн хийж, гүйцэтгэсэн ажлыг дараах 3 үндсэн чиглэлээр, нийт 1000 хүртэл оноогоор үнэлнэ. Үүнд:
 - I. Сургалтын үйл ажиллагаа,
 - II. Эрдэм шинжилгээ, судалгаа шинжилгээний ажил,
 - III. Сургууль, олон нийтийн үйлчилгээ.
- 2.2. Аттестатчилалын төв болон салбар комиссыг Ректорын тушаалаар томилох бөгөөд төв комисс нь проректорууд, газар, албадын дарга нараас, салбар комисс нь тухайн бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалт эрхэлсэн дэд захирал, тэргүүлэх профессор, багш нарын зөвлөлийн гишүүн, бусад бүрэлдэхүүн сургуулийн тэргүүлэх профессорууд, ШУТИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүдээс тус тус бүрдэнэ.
- 2.3. Профессор багшийн нэгдсэн дүн нь:



Ректорын 2013 оны . . . дүгээр сарын . . .-ны
өдрийн . . . тоот тушаалын 1 дүгээр хавсралт

- Төв болон салбар комиссоор хянан баталгаажуулсан багшийн өөрийн үнэлгээ
 - Оюутны үнэлгээ зэргээс бүрдэнэ
- 2.4. Профессор багш бүр өөрийн хийж гүйцэтгэсэн ажлыг үнэн зөв үнэлүүлэх үүднээс батлагдсан загварын дагуу тайлан бичиж, өөрийн үнэлгээ хийнэ. Энэхүү өөрийн үнэлгээний тайланг дээрх 3 чиглэлийн дагуу гаргах бөгөөд нотлох баримтуудыг бүрдүүлж, гол амжилтаа нэгтгэн, мөн зорилт, төлөвлөсөн ажлаа бичсэн тайлбараа хавсаргана.
- 2.5. Оюутны үнэлгээг хичээлийн жилд тухайн профессор багшийн хамгийн олон оюутанд заасан нэг хичээлээр, оюутнуудыг бүрэн хамруулан, Сургалтын бодлого зохицуулалтын газраас боловсруулсан асуулга бүхий тусгай маягтын дагуу авна. Асуулгын эх материалыг Сургалтын бодлого зохицуулалтын газар нэгтгэн, дүнг багшийн веб хуудсаар дамжуулан хүргэнэ.
- 2.6. Багшийн ажлыг үнэлэх үйл ажиллагааг дараах дарааллаар явуулна. Үүнд:
- Багш өөрийн үнэлгээний тайланг загварын дагуу бичиж, зохих хавсралтуудын хамт багцлан тэргүүлэх профессор /тэнхимийн эрхлэгч/-т өгнө.
 - Оюутнаар багшийг үнэлүүлэх үйл ажиллагааг Сургалтын бодлого зохицуулалтын газраас эрхлэн зохион байгуулж, үр дүнг нэгтгэн холбогдох сургуульд хүргүүлнэ.
 - Профессорын баг/тэнхим/-ийн хамт олон багш бүрийн өөрийн үнэлгээний тайланг хэлэлцэн үнэлгээ өгөх бөгөөд үүнд тулгуурлан тэргүүлэх профессор/тэнхимийн эрхлэгч/ багш бүрт тодорхойлолт(нэг хуудас орчим) гаргана.
 - Салбар комиссын хянан шалгасан багшийн өөрийн үнэлгээний тайлан, оюутны үнэлгээтэй нэгдсэн дүнг төв комисс судлан, нягтлан тодруулах замаар үнэлгээг баталгаажуулна.
 - Бодитой бус үнэлэн тогтоогдсон, гомдол маргаан гарсан зэрэг тохиолдолд нэгдсэн дүнг салбар комисст буцааж зөрчлийг арилгуулна.
 - Төв комисс нь салбар комиссын тайланг нэгтгэн ШУТИС-ийн захиргаанд танилцуулж, холбогдох шийдвэр гаргуулна.
- 2.7. Төв болон салбар комисс багш нарын ажлын үндсэн чиглэл, шалгуур үзүүлэлт бүрээр гаргасан өөрийн үнэлгээг хянан шалгаж, баталгаажуулахад дараах зүйлсийг анхаарвал зохино. Үүнд:
- а. Гүйцэтгэх ажлын төрөл бүрд тохирох, үндэслэх баримтыг ялган ангилах,
 - б. Хамрагдаж буй хүмүүсийг харьцуулсан нотолгоог гаргаж авах,
 - в. Янз бүрийн баримт материалуудын ач холбогдлыг харьцуулан тодорхойлох,



Ректорын 2013 оны . . . дүгээр сарын . . .-ны
өдрийн 12/3 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

г. Нэг албан тушаалд ажиллаж байгаа профессор багш нарыг холбогдох ажлын үзүүлэлтээр нь хооронд нь харьцуулан дүгнэх

2.8. Нийлбэр оноогоор багш нарыг дараах түвшинд үнэлнэ. Үүнд:

А(800-1000 оноо). Тухайн сургуулийн хэмжээнд уг албан тушаалын багш нараас ажлын үр дүнгээр хамгийн сайн түвшний хүмүүс,

В(600-800 хүртэл оноо). Тухайн сургуулийн хэмжээнд уг албан тушаалын багш нараас ажлын үр дүнгээр сайн түвшний хүмүүс,

С(400-600 хүртэл оноо). Ажлын гүйцэтгэл нь зарим үзүүлэлтээр дутагдалтай боловч мэргэжил, ур чадвараа дээшлүүлэн дадлага туршлага хуримтлуулан түвшингээ ахиулах боломжтой, дунд түвшний хүмүүс,

Хангалтгүй(0-400 хүртэл оноо). Ажлын гүйцэтгэл нь зохих минимум стандарт хангаагүй хүмүүс,

2.9. Багшийн үндсэн орон тоон дээр ажиллаж байгаа нийт профессор багш нар аттестатчилалд хамрагдах бөгөөд тогтоосон хугацаанд аттестатчилалд ороогүй багш төв комисст тайлангаа хамгаална

2.10. Профессор багш бүр аттестатчилалын дүнд дүгнэлт хийж, ололттой ба цаашид анхаарвал зохих асуудлыг тусгасан “Багш өөрийн хөгжлийн хөтөлбөр” боловсруулж мөрдөнө.

2.11. ШУТИС-д 30-аас дээш жил ажилласан профессор багш хүсэлт гаргавал аттестатчилалд орохгүй байж болох бөгөөд түүний албан тушаалын ангилал нь хэвээр хадгалагдана.



Ректорын 2013 оны . . . дүгээр сарын . . .-ны
өдрийн АЗБ тоот тушаалын 1 дүгээр хавсралт

Гурав. Профессорын баг, тэнхимийн рейтинг тогтоох үйл ажиллагааг зохион байгуулах

- 3.1. Профессорын баг, тэнхимийн рейтинг тогтоох ажлыг аттестатчиллын төв комисс Ректорын тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэнэ. ШУТИС-д явагдаж байгаа бүхий л үйл ажиллагааны чанараар профессорын баг/тэнхим/-ийн рейтинг тодорхойлогдох бөгөөд тухайн профессорын баг/тэнхим/-ийн профессор багш нарын аттесчилалын үр дүнгээс шууд хамаарна.
- 3.2. Профессорын баг/тэнхим/-ийн рейтинг тогтоох үйл ажиллагааг дараах дарааллаар явуулна. Үүнд:
- Профессорын баг/тэнхим/-ийн рейтинг тогтоох үйл ажиллагаанд тухайн бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл тусгай маягтаар үнэлгээ өгөх бөгөөд профессорын баг/тэнхим/ бүрт тодорхойлолт гаргаж, төв комисст хүргүүлнэ.
 - Төв комисс удирдамжийн дагуу профессорын баг, тэнхимүүдийн рейтинг тогтоон, рейтингийн дүнгээр байр эзлүүлж,
 - Бүрэн хангалттай,
 - Хангалттай,
 - Дунд зэрэг,
 - Дундаас доош,
 - Хангалтгүй,гэсэн 5 түвшингээр эрэмбэлнэ.
 - Бүрэн хангалттай үнэлгээ авсан хамт олныг шагнаж урамшуулах, хангалтгүй үнэлгээ авсан профессорын баг/тэнхим/-ийн тэргүүлэх профессор/тэнхимийн эрхлэгч/-ыг өөрчлөх, сонгон шалгаруулалтаар шинээр томилох, шаардлагатай гэж үзвэл профессорын баг/тэнхим/-ийг татан буулгах зэрэг саналаа холбогдох хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

Профессорын баг тэнхимүүд рейтингийн эцсийн дүнг үндэслэн анхаарвал зохих сул талдаа дүгнэлт хийж, дараагийн рейтинг тогтоох хүртлэх хугацаанд түүнийг сайжруулах, сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ судалгаа, багш нарын мэргэжил мэдлэг дээшлүүлэх, эрдэм дэлгэрүүлэх болон оюутан сурагчид олон нийттэй холбогдох үйл ажиллагаагаа төгөлдөржүүлэх зэрэг холбогдох зорилтууд тавьж ажлын төлөвлөгөөндөө тусган ажиллана.